



Зочлох Виз (Ангилал 600)

Жуулчны төрөл – Бүрдүүлэх материалын жагсаалт - Монгол Улсын виз мэдүүлэгчид

Таны виз мэдүүлгийг шийдвэрлэхэд шаардагдах гол бичиг баримтуудыг энд багтаасан тул танд жагсаалтыг зааварчилгаа болгон хэрэглэхийг зөвлөж байна.

Жагсаалтыг хэрхэн ашиглах тухай

1. Виз мэдүүлэгийн маягт дээр гарын үсэг зурахаас өмнө энэ жагсаалтын дагуу мэдүүлэгт шаардлагатай бүхий л бичиг баримтийг бүрдүүлсэн эсэхээ сайтар хянаарай.
2. Мэдүүлгийн маягтыг зөв бөглөн шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлсэн гэж үзвэл мэдүүлгийн маягт дээр гарын үсэг зурж он сар өдөрөө тэмдэглэх хэрэгтэй.
3. Та энэ жагсаалтыг бөглөн мэдүүлгийн маягт болон холбогдох бичиг баримтийн хамт хавсаргасан байна.

Бусад чухал мэдээлэл:

Таны виз мэдүүлгийн хариуг мэдүүлэг өгөх үед ирүүлсэн мэдээлэл болон бичиг баримтыг үндэслэн шийдвэрлэх магадлалтайг анхаарвал зохино. Мөн мэдүүлэг шийдвэрлэх явцад нэмэлт бичиг баримт шаардаж болзошгүй.

Анхаарвал зохих зүйлс:

- Мэдүүлгийн маягт дээр өөрийн холбогдох и-мэйл хаягыг заавал тэмдэглэсэн байх;
- Гадаад паспортаас бусад бичиг баримтын эх хувийг ирүүлэхгүй байх;
- Албан бичиг баримтийг нотариатаар баталгаажуулсан байх;
- Паспортын зурагтай хуудасны хуулбарыг өөртөө үлдээнэ үү (эрүүл мэндийн шинжилгээнд орох тохиолдолд хэрэглэнэ);
- Монгол хэл дээрх бүх бичиг баримтыг баталгаат орчуулгаар англи хэлрүү хөрвүүлсэн байх.

Маягт болон Хураамж	✓
Маягт 1419: Зочлох Виз Мэдүүлэг - Жуулчны Төрөл http://www.border.gov.au/Forms/Documents/1419.pdf - Англи хэлээр бөглөнө үү.	<input type="checkbox"/>
Маягт 54: Гэр бүлийн гишүүдийн жагсаалт http://www.border.gov.au/Forms/Documents/54.pdf - Англи хувилбар	<input type="checkbox"/>
Маягт 956: Зуучлагч агентлаг эсвэл бусад этгээдэд итгэмжлэл гаргах http://www.border.gov.au/Visasupport/Documents/956.pdf Энэ маягтыг зуучлагч агентлаг эсвэл ямар нэгэн этгээдэд итгэмжлэл гарган таны мэдүүлэгтэй холбоотой мэдээлэл авах зөвшөөрөл олгох тохиолдолд л ирүүлнэ.	<input type="checkbox"/>
Виз мэдүүлэгийн хураамж: www.china.embassy.gov.au/bjng/DIACtemp.html	<input type="checkbox"/>
Хувийн Бичиг Баримтууд	✓
Хүчинтэй гадаад паспорт (эх хувь)	<input type="checkbox"/>
Гадаад паспортын зурагтай болон мэдээлэлтэй нүүрний хуулбар 2 хувь	<input type="checkbox"/>
Паспортын хэмжээтэй зураг нэг хувь. Зургийг мэдүүлгийн маягтын нүүр хуудсанд	<input type="checkbox"/>

хавсаргасан байна.	
Мэдүүлэгт багтсан хүн бүрийн иргэний үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар	<input type="checkbox"/>
Санхүүгийн Бичиг Баримтууд	<input checked="" type="checkbox"/>
Аялалын зардалаа даах санхүүгийн чадвартайг нотлох баримтууд. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Таны хуримтлуулсан мөнгөн хөрөнгийг харуулах банкны хадгаламжийн дэвтэр; • Банкны тодорхойлолт эсвэл хэсэг хугацаанд олгосон цалингийн хуудас; • Кредит картын төлбөрийн хуудас; • Бусад үндсэн хөрөнгө болон орлогын баримтууд 	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Хэрэв таны аялалын зардлыг Австрали улсад амьдарч буй найз эсвэл хамаатан садан тань хариуцах бол санхүүжүүлэх тухай мэдэгдэл мөн санхүүжүүлэх чадвартайг харуулах нотолгоо баримт ирүүлнэ.	<input type="checkbox"/>
Ажил болон Сургуулийн Тодорхойлолт	<input checked="" type="checkbox"/>
Хэрэв та ажил эрхэлдэг бол ажил олгогчын гарын үсэгтэй тодорхойлолт. Үүнд доорх мэдээлэл багтсан байна: <ul style="list-style-type: none"> • таны албан тушаал болон цалин; таны ажил эрхэлсэн нийт хугацаа; • чөлөө олгосон зөвшөөрөл; • тодорхойлолт гаргасан ажил олгогчтой холбоо барих мэдээлэл; • нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар 	<input type="checkbox"/>
Хэрэв та ямар нэгэн бизнес эрхэлдэг бол компаны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	<input type="checkbox"/>
Хэрэв та тэтгэвэрт гарсан бол тэтгэвэрийн дэвтрийн хуулбар	<input type="checkbox"/>
Хэрэв та оюутан бол сургуулийн тодорхойлолт	<input type="checkbox"/>
Бусад Бичиг Баримтууд	<input checked="" type="checkbox"/>
Хэрэв та Австрали улсад амьдарч буй хамаатан садан, найзындаа зочилох бол доорх бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Урилга, урьж буй этгээдийн нэр болон холбоо барих утас • Урьж буй этгээдийн гадаад паспортын нүүр хуудас болон Австралийн визний хуулбар 	<input type="checkbox"/>
Зарим виз мэдүүлэгчид нэмэлт бичиг баримт ирүүлэх шаардлага гарч болзошгүй. Доорх мэдээлэлтэй танилцана уу.	<input type="checkbox"/>
Мэдүүлэг Өгөгчийн Мэдээлэл	<input checked="" type="checkbox"/>
Хэрэв та хэн нэгний өмнөөс виз мэдүүлж буй бол , доорх мэдээллийг ирүүлнэ үү: Овог нэр.....Төрсөн он/сар/өдөр: Гар утас: Үнэмлэх эсвэл паспортын дугаар: Гарын үсэг:	
Албаны тэмдэглэгээ: AVAC төвийн ажилтан үнэмлэх болон паспортыг шалгасан	<input type="checkbox"/>
НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ/БИЧИГ БАРИМТ	
<ul style="list-style-type: none"> • Хэрэв та одоогоор ямар нэгэн өөр ангиллийн Австралийн визтэй эсвэл виз мэдүүлсэн бол холбогдох мэдээллийг ирүүлнэ үү. • Хэрэв та одоогоор өөр гадаад паспорт эзэмшдэг эсвэл эзэмшиж байсан бол холбогдох мэдээллийг ирүүлнэ үү. • Хэрэв та эхнэр/нөхөр эсвэл эцэг/эхээ дагалдан явахаар виз мэдүүлж буй, таны эхнэр/нөхөр эсвэл эцэг/эх виз мэдүүлсэн, хүчинтэй визтэй бол түүний визний мэдээлэл болон төрөл садангийн нотолгоог ирүүлнэ үү. <p>Санамж: Хэрэв та одоогоор Австралийн визтэй бол энэ тухайгаа мэдэгдэх нь маш чухал, учир нь танд шинээр виз олгомогц таны өмнөх виз хүчингүй болно.</p> <p>Виз мэдүүлэг өгсөний дараа эрүүл мэндийн шинжилгээ хийлгэх шаардлага бий эсэхийг бид танд мэдэгдэх болно. Тийнхүү шаардвал та цагаачлалын албаны зөвшөөрөлтэй эмнэлэгт хандан шинжилгээнд орох асуудлаа өөрөө зохицуулах хэрэгтэй.</p> <p>Монгол улс дахь албан ёсны зөвшөөрөлтэй эмнэлэгийн талаарх мэдээллийг</p>	

http://www.border.gov.au/about/contact/offices-locations/mongolia -д орж харна уу.	
18 Нас Хүрээгүй Виз Мэдүүлэгчид	✓
<p>Эцэг/эх болон үр хүүхдийн хоорондын харицааг нотлох баримт</p> <ul style="list-style-type: none"> • хүүхдийн төрсний гэрчилгээ, эцэг эхийн нэр тус тус бичигдсэн байх • эцэг эхийн гэрлэлтийн гэрчилгээ (хэрэв ирүүлэх боломжтой бол) <p>Хэрэв гэрчилгээн дээрх мэдээлэл дутуу эсвэл зөрчилтэй байвал бусад албан баримт ирүүлэхийг шаардана.</p> <p>Санамж: Хэрэв гэрчилгээ дээрх мэдээлэл дутуу эсвэл буруу ташаа бол бусад албаны бичиг баримт ирүүлэхийг шаардана</p>	<input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Хүүхдийн сургуулийн тодорхойлолт (хэрэв ирүүлэх боломжтой бол)	<input type="checkbox"/>
<p>Хүүхэд эцэг/эх эсвэл хууль ёсны асран халамжлагчгүйгээр аялах бол доорх бичиг баримт шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хамт зорчихгүй эцэг эхийн иргэний үнэмлэх • Хамт зорчихгүй эцэг эхийн гарын үсэгээр баталгаажсан итгэмжлэл эсвэл Маягт 1229 ирүүлнэ. Мэдэгдэлд/ итгэмжлэлд доорх мэдээлэл багтсан байна, үүнд: <ul style="list-style-type: none"> - хүүхдээ аялахад зөвшөөрч буй талаар - хэр хугацаагаар аялах болон зорчих он сар өдөр - нэг удаа зорчих эсвэл олон удаа зорчих зөвшөөрөл олгосон тухай - холбоо барих утас хаяг гэх мэт <p>Итгэмжлэлийн Маягт 1229: 18 нас хүрээгүй мэдүүлэгч Австрали улсад аялах зөвшөөрөл олгох http://www.border.gov.au/Forms/Documents/1229.pdf - г татаж авна уу.</p>	<input type="checkbox"/> <input type="checkbox"/>
<p>Хэрэв хүүхдийг Австралид зорчих хугацаанд хагралзагч этгээд нь түүний эцэг/эх, хамаатан садан болон хууль ёсны асран халамжлагч биш бол тухайн этгээд Маягт 1257-г бөглөж хүүхдийг Австралид байх хугацаанд арсан халамжилна гэдгээ мэдэгдэх ёстой.</p> <p>Маягт 1257: http://www.border.gov.au/Forms/Documents/1257.pdf - г татаж авна уу.</p>	<input type="checkbox"/>

Виз мэдүүлэгч би:

- энэ жагсаалтын дагуу шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлсэн; эсвэл
- энэ жагсаалтад заасан, виз мэдүүлэгт шаардагдах бүх бичиг баримтыг бүрдүүлээгүй, түүнчлэн мэдүүлгийн хариуг миний бүрдүүлсэн мэдээллийг үндэслэн шийдвэрлэх магадлалтайг ойлгож байна.

Виз мэдүүлэгч би:

- цагаачлалын албатай и-мэйлээр холбогдохыг зөвшөөрч байна; эсвэл
- цагаачлалын албатай и-мэйлээр холбогдохыг зөвшөөрөхгүй байна, түүнчлэн бичиг баримтын эх хувийг Бээжин дэх цагаачлалын албанд хүргүүлэхтэй холбоотой нэмэлт хугацаа болон төлбөр шаардагдах магадлалтайг ойлгож байна.

Санамж: Хэрэв виз мэдүүлэгч 18 нас хүрээгүй бол түүний эцэг/эх эсвэл асран халамжлагч түүнийг төлөөлөн гарын үсэг зурна.

Виз мэдүүлэгчийн нэр:	Гарын үсэг:	Он сар өдөр:/...../.....
---------------------------------------	-----------------------------	--